

“ХӨВСГӨЛ-ЭРЧИМ ХҮЧ” ХХК

***ТООЛУУР, ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР БОЛОН БУСАД МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

Дугаар: ХӨАЭХХК/202003043

Мөрөн хот

Хөвсгөл-Эрчим Хүч ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ТООЛУУР, ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР БОЛОН БУСАД МАТЕРИАЛ** –ийг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.

Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 сарын 23-ны өдрийн 10 цаг 10 минут¹**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг,
Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн байр,
утас: 70382328, 88089108**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 1.
 - 2.
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан цахим хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
4. Тогтмол үнэ
 - 4.
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: <i>Хөвсгөл-Эрчим Хүч ХХК</i>
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: ТООЛУУР, ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР БОЛОН БУСАД МАТЕРИАЛ, ХӨАЭХХХК/202003043
ТООЗ 1.1	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй.</i>
ТООЗ 1.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Өөрийн хөрөнгө төгрөг, 2020 онд санхүүжих дүн: 35 281 500 төгрөг</i>
ТООЗ 1.1	Тендерт оролцогч нь ТООЗ-ийн 4.2.1-4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж, эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу холбогдох баримт, нотолгоог тендерт хавсарган захиалагчид ирүүлнэ.
	Б. Тендерийн баримт бичиг
ТООЗ 1.1	Тендерт оролцогч тендерийн баримт, бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх шаардлагатай бөгөөд тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлээгүй байх, маягтыг дутуу бөглөж ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
ТООЗ 1.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Тодоруулгыг www.tender.gov.mn сайтаар дамжуулан оролцогчид өгнө.
ТООЗ 1.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 0 хоногоос багагүй байна.
	В. Тендер бэлтгэх
ТООЗ 3.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна.

<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг дор дурьдсан хэсэг, бүлэгт заасан дараалалд нийцсэн иж бүрдэл баримт бичиг болгон бэлтгэх буюу шаардлагатай бол ТӨӨЗ-д заасны дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтийг тусгасан байна. Үүнд:</p> <p style="text-align: center;">I. ХЭСЭГ</p> <p>Бүлэг 1.Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу бэлтгэсэн баримт бичиг, нотлох баримт Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт Бүлэг 3. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуурт хамаарах дараах баримт бичгийг ирүүлэх. Үүнд: -ТӨӨЗ-ны 3.1-д заасан нэмэлт материал, -тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай нотлох баримт -Тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл -тендерт оролцогчийг тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай нотлох баримтууд Бүлэг 4. Тендер шалгаруулалтын үнэлгээнд хамаарах дараах баримтыг тендерийн багц тус бүрд ирүүлэх.Үүнд: -Тендерийн маягт - Үнийн хуваарь -дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн нэр, өртөгийг дотоод валютаар илэрхийлж ирүүлнэ</p> <p style="text-align: center;">II. ХЭСЭГ</p> <p>Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтыг хангах талаар тендерт оролцогчийн санал, нотлох баримтыг тендерт заасан нөхцөл бүрээр гаргах. Үүнд: - Санал болгосон бараа нь захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолт болон стандартад нийцэхийг зүйл заалт нэг бүрээр нотлон харуулсан тайлбар, нотлох баримтыг бэлтгэж ирүүлэх ба нотлох баримтыг нийтлэл, өнгөт зураг, өгөгдөл, орц норм, үйлдвэрлэгчийн тогтоолгосон стандарт, итгэмжлэгдсэн лаборатороор шинжилгээ хийлгэсэн тухай шинжилгээний баримт бичиг, барааны тэмдэг, холбогдох хэдэн үйлдвэрлэгч, борлуулагчийн онлайн хаягаас татаж харьцуулж болох талаарх зөвлөмж хэлбэрүүдтэй байж болно. –Тендерт өөр стандарт барааны катлогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүүц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна. -барааны техникийн тодорхойлолт, ашиглалтын заавар, барааны гарал үүсэл, чанарын сертификат, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрөлийг ирүүлнэ.</p> <p style="text-align: center;">III. ХЭСЭГ</p> <p>Бүлэг 6. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлийг зөвшөөрөх эсэх санал, шийдвэрийг багц тус бүрд ирүүлэх Бүлэг 7. Гүйцэтгэлийн баталгаа шаардсан тохиолдолд ирүүлэх эсэх саналыг багц тус бүрд ирүүлэх /уг тендерт шаардлагагүй/ Бүлэг 8. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт авах эсэх талаарх санал /уг тендерт шаардлагагүй/</p>
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйл буюу тендерт</p>

оролцогч гэрээ хэрэгжүүлэх чадвартайгаа нотолж тендерт ирүүлэх чадварын мэдээллүүд: Үүнд:

1. Сүүлийн 1 жил буюу 2019 онд санал болгож буй багцын үнийн дүнгийн 80 хувиас дээш хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт/ ирүүлнэ.

2. Сүүлийн 1 жил 2019 онд санал болгож буй багцын үнийн дүнгийн ижил төстэй нийлүүлсэн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагатай байх.

3. Сүүлийн 1 жил буюу 2019 онд санал болгож буй багцын үнийн дүнгийн нийлүүлсэн барааны төсөвт өртгийн 70 хувиас багагүй өртөг бүхий гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлагатай байх.

3. Татвар, харилцагч банк, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ. Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр төлбөртэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

4. Тендерт оролцогч олон багцтай тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизм, багаж хэрэгсэл, агуулах, барааны нөөцийг танилцуулах бөгөөд тэдгээр нь санал болгож буй тендерийн саналтай давхардсан тохиолдолд болон уг мэдээллийг ирүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн нөхцөлд оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно. Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний хугацаа, өртөг, захиалагчийн албан ёсны хаяг, байршил, харилцах утасны дугаарын талаарх мэдээллийг ирүүлнэ.

5. Тендерт оролцогчийн санал болгосон нийт инженер техникийн ажилтан, ажилчид нь өөрийн компанийн ажилтан, байх ба тэдгээр ажилтнуудын НДШ-ийг тендерт оролцогч өөрөө төлсөн болохыг НД-ын байгууллагын НД№7, НД№8 маягтаар гаргасан тодорхойлолт лавлагаа, ажилтны нийгмийн даатгалын дэвтэрийн наториатоор батлуулсан хуулбарыг тус тус үндэслэн тогтооно. Тухайн барааг нийлүүлэхэд шаардлагатай инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг захиалагчаас тогтоосноор дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:

Албан тушаал	Мэргэжил, боловсрол	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтэрийн дугаар
		1	1	

Энэ хүснэгтэд заасан ИТА, мэргэжилтэй ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр зэрэг баримт бичгийн эх хувиас татсан хуулбарыг тендерт ирүүлнэ. ИТА, мэргэжилтэй ажилчид нь хэдэн ч багцын гэрээнд ажиллаж болно, тендерт оролцогчийн үндсэн ажилчин байна. тендерт оролцогчийн үндсэн ажилчин гэдгийг батлаж ажилчдын нэрийн дагуу 2019 оны 6-12 дугаар саруудын болон 2020 оны 1-3 саруудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн баримт бичиг НД-7, НД-8 маягтаар тодорхойлсон мэлээлэл, өр төлбөргүй талаарх лавлагаа зэргийг нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулж ирүүлнэ. № ТШМ-2-1.5 хүснэгтэд байгаа үндсэн мэргэжлийн ажилчин, ажилтнуудын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, уг ажилтнуудын туршлагын талаархи мэдээллийг тус тус ирүүлэх.

6. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг наториатаар батлуулж ирүүлнэ.

7. Аж ахуйн нэгжийн талаарх танилцуулга мэдээллийг №ТШМ-2-3-аар буюу хавсралт №1-ээр гаргаж ирүүлнэ

	<p>8. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хувьль болон бусад хувьль тогтоомжийг зөрчсөн нөхцөл бүхий тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзана.</p> <p>9. Санал болгож буй багцын барааны нийлүүлэлтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>10. Санал болгож буй багцын санхүүжилтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Дээрхи нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажилтгүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 1 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 3.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТӨӨЗ 3.1	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: “Incoterms 2000
ТӨӨЗ 3.1	Бараа хүргэгдэх газар: Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн төв байр
ТӨӨЗ 3.1	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн төв байр
ТӨӨЗ 3.1	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан СІР үнээс гадна дараах үнээр санал болгож болно.
ТӨӨЗ 3.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй” Зөвхөн тухайн барааны зах зээлийн нэгж үнэ гэрээнд заасан үнээс 15 хувь түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцож барааны нэгж үнийг бууруулах өөрчлөлтийг хийнэ. Барааны үнэд үүнээс өөрчлөлт хийхийг хориглож энэ заалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.
ТӨӨЗ 3.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТӨӨЗ 3.1	Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл: “шаардлагатай” Тендерт оролцогч өөрийн үйлдвэрлээгүй бараа, бүтээгдэхүүнийг тендерт санал болгож байгаа тохиолдолд үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, эсхүл гэрээт борлуулагчийн зөвшөөрлийг ирүүлнэ.
ТӨӨЗ 3.1	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх бөгөөд тайлан ирүүлсэн жилд ашигтай ажилласан байна.

<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1 жил</p> <p>Сүүлийн 1 жилд дээрх багцыг нийлүүлж байсан гэрээний тухай мэдээллийг дараах хүснэгтээр ирүүлнэ:</p> <table border="1" data-bbox="459 331 1449 477"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Гэрээний нэр</th> <th rowspan="2">Барааны нэр</th> <th rowspan="2">Гэрээний үнэ /мян.төг/</th> <th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th> </tr> <tr> <th>Нэр</th> <th>хаяг</th> <th>Утасны дугаар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> <p>Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч байгууллагуудтай сүүлийн 1 жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>	№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл			Нэр	хаяг	Утасны дугаар							
№	Гэрээний нэр					Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл										
		Нэр	хаяг	Утасны дугаар														
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <i>Нийлүүлсэнээс хойшхи хадгалалт, хамгаалалтаас шалтгаалсан аливаа чанар аюулгүй байдлыг захиалагч хариуцна.</i></p>																	
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Борлуулалтын хэмжээ: Санал болгож байгаа үнийн дүнгийн 80%-тай тэнцүү байна. Сүүлийн 1 жил буюу 2019 онд ижил төрлийн бараа нийлүүлсэн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагатай байх.</p>																	
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019 он</p>																	
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <i>Гэрээт ажилд ашиглах дурьдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үзүүлэлт, жагсаалтыг доорх хүснэгтэд зааснаар бэлтгэж, тэдгээрийн гэрчилгээний эхээс татсан хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ /тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь компанийн өөрийн эзэмшлийнх эсхүл түрээсийнх байж болох бөгөөд 2018 оны түрээсийн гэрээний эх хувийг ирүүлнэ/ Үүнд:</i></p> <table border="1" data-bbox="467 1126 1457 1541"> <thead> <tr> <th>Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт</th> <th>Тоо, хэмжээ</th> <th>Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар</th> <th>Эзэмшдэг байгууллага иргэний нэр</th> <th>Чанар байдал, ашиглалтад орсон огноо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр зориулалтыг бичнэ.</td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table>	Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт	Тоо, хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар	Эзэмшдэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалтад орсон огноо	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр зориулалтыг бичнэ.											
Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт	Тоо, хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар	Эзэмшдэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалтад орсон огноо														
Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр зориулалтыг бичнэ.																		
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Төсөвт өртгийн 30%-иас багагүй байх</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.</p> <p><i>-Байгууллагын харуулах банкин дахь дансны үлдэгдэл /банкны тодорхойлолт, дансны үлдэгдлийн баталгаагаар тодорхойлно./</i></p> <p><i>-Арилжааны банкнаас зээл олгох бололцоотой болохыг нотлох тодорхойлолт</i></p> <p><i>- Үнэт цаасны тухай хуулийн 5.1-д заасан үнэт цаасаар</i></p>																	
<p>ТӨӨЗ 3.1</p>	<p>Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2019 онд ашигтай ажилласан байна.</p>																	

<p>ТООЗ3.1</p>	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”</p> <p>Дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоход бол тендерт оролцогчид дараах шаардлага тавина. Үүнд:</p> <p>Тендерт оролцогч нь давуу эрх тооцуулах хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлэх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 103, 2014 оны 18 дугаар тогтоол, Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар баталсан давуу эрх тооцох аргачлалын нөхцлийг хангаж буйг нотлох баримтыг тендерийн бүрэлдхүүнд тусгай хэсэг болгон ирүүлнэ. Дотоодын давуу эрх тооцуулахаар санал болгосон барааны гарал үүслийг нотлох баримт бичгийг тендерт хавсарган ирүүлнэ.</p> <p><i>Дотоодын давуу эрхийн зөрүүг үнэлгээнд харгалзах бөгөөд захиалагч Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг ашиглан үнэлгээ хийнэ.</i> Тендерийн үнийг харьцуулахдаа “дотоодын давуу эрхийн зөрүү” тооцно, Дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах талаар дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд: -Тендерт оролцогчийн орон нутгийн давуу эрх тооцуулах хүсэлт, - Санал болгосон барааны өртгийн 50-аас багагүй хувь нь тухайн орон нутагт бий болсон гэдгийг нотлох баримт бичиг</p> <p>Жич: Тендерт оролцогч албан хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй бол давуу эрх тооцохгүй.</p>
<p>ТООЗ 3.1</p>	<p>Тендерт оролцогчийн санал болгосон бараа нь захиалагчаас шаардсан тухайн барааны тодорхойлолт /стандарт/-ын үзүүлэлт, нөхцөл тус бүрийг хангаж буйг харуулах техникийн тодорхойлолт, тайлбар нотлохыг баримтыг бэлтгэж тендерт ирүүлнэ. Ингэхдээ ТООЗ 21.1-ийн II-ийн ”5”-д заасан тайлбарын дагуу бэлтгэнэ</p>
<p>ТООЗ 6.1</p>	<p>Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.</p>
<p>ТООЗ 7.1</p>	<p>Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: цахим системээр ирүүлэх тохиолдолд хувь заахгүй</p>
<p>Г. Тендер ирүүлэх</p>	
<p>ТООЗ 7.1</p>	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН- ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МБ, нэг файлын хэмжээ 15 МБ байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн төв байр. Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан Б.Даваасүрэн</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг, өөрийн байранд</p> <p>Аймаг, хот: Хөвсгөл аймаг Мөрөн хот</p> <p>Улс:Монгол Улс</p>

ТӨӨЗ 7.1	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <i>Тендерт оролцогч нь тендерийн дугаар бүрийг дугаарлаж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тендерийн эхний нүүрэнд тендерийн товъёог хөтөлж оруулна.</i>
ТӨӨЗ 7.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул тендер хүлээн авах хугацаанаас хоцорсон тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Огноо: <i>2020 оны 04 дугаар сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 7.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7-р баг, Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн байранд Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн байранд. 1 давхар ХАА хариуцсан ажилтан Б.Даваасүрэнгийн өрөөнд Аймаг, хот: <i>Хөвсгөл аймаг</i> Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>2020 оны 04 дугаар сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 10 минут</i>
ТӨӨЗ 7.1	<i>Арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах,</i> <i>Томоохон зөрүү тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх,</i> <i>-Тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах</i>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТӨӨЗ 8.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <i>0 хувь</i> Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <i>0 хувь</i>
ТӨӨЗ 8.1	Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй тухай мэдэгдлүүдийг www.tender.gov.mn www.khovsgoltender.mn сайтад нийтэлж, оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгслээс үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Мэдэгдлийн эх хувийг баталгаат шуудангаар илгээнэ.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ТООЛУУР, ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР БОЛОН БУСАД МАТЕРИАЛ

№	Материалын нэр	Техникийн тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	лент	тажема том	ш	100
2	Цүү		ш	195
3	Уян хоолой		ш	60
4	Пласмасан хоолой 50	50-т	м	148
5	Шүршдэг саарал будаг	Солонгос	ш	38
6	Гэрэл		ш	10
7	Патрон		ш	10
8	Унтраалга		ш	5
9	Төмрийн шруп	3см	хайрцаг	7
10	Будаг хар		кг	5
11	нугас		ш	70
12	Төмрийн өрөмний хошуу		ш	2
13	Лазер метр		ш	1
14	Хадагч		ш	2
15	хадаас		хайрцаг	40
16	Хаалга /том/	Монголд үйлдвэрлэсэн. Төмөр хаалга.	ш	7
17	Хаалга /жижиг/		ш	3
18	Электрод-2мм	2мм	боодол	21
19	Тайрагчны ир		ш	81
20	Үзүүрийн муфть	70-120мм	ш	16
21	0.4кВ муфть дундын	0.4кВ	ш	35
22	муфть дундын	70-120мм	ш	7
23	Тоолуур-	5А 3фаз ухаалаг	ш	7
24	Гүйдлийн трансформатор	150/5А	ш	5
25	Гүйдлийн трансформатор	200/5А	ш	5
26	Гүйдлийн трансформатор	300/5А	ш	5
27	Гүйдлийн трансформатор	600/5А	ш	5
28	Гүйдлийн трансформатор	800/5А	ш	3
29	1 фазын автомат 25А	25А	ш	63
30	3 фазын автомат 400А	400А	ш	1
31	3 фазын автомат 100А	100А	ш	63
32	3 фазын автомат 160А	160А	ш	1
33	3 фазын автомат 250А	250А	ш	1
34	Зажим		ш	948
	Нийт			35 281 500

Дээрх техникийн тодорхойлолтыг хангаж байгааг нотлох зураг болон холбогдох баримтыг хавсаргасан байна.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

“ХӨВСГӨЛ-ЭРЧИМ ХҮЧ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ОЧИРХУЯГ

НИЙЛҮҮЛЭГЧ

“АААААААААА” ХХК-ИЙ ЗАХИРАЛ
Н.ББББББББББ

*Хөвсгөл аймгийн
нийлүүлэх гэрээ.*

Дугаар № ХӨ-2017/3.5.3-А/1

..... хот/аймаг

Нэг талаас *Хөвсгөл аймгийн ...* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “.....” *ХХК-ий захирал Н.ББББББББ* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]